



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 1167

Шивээговь сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Даян дэлхийн байгаль орчны сангийн жижиг төслийн хөтөлбөрийн хүрээнд Энх Агуулга сангийн хэрэгжүүлэх гэж буй “Иргэдийн оролцоотой ногоон сумыг бий болгох” MON/SGP/OP7/Y1/CORE/CD/2021/05 төслийн хүрээнд 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Э.Баярмагнай

(Газрын даамал)

О.Отгонбаяр

(Байгаль хамгаалагч)

С.Отгонбаатар


(2 дугаар багийн Засаг дарга)

Н.Амаржаргал

(1 дүгээр багийн Засаг дарга)

2. “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн хэрэгжилтийг ханган үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн нийт /гишүүд/-д, ажлын гүйцэтгэлийг 14 хоногоор танилцуулан тайлагнахыг ажлын хэсгийн дарга /Ч.Сугармаа/-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн /О.Болормаа/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

4212104.1